



ОХУ-ын Алтайн бүгд найрамдах улс Монгол улсын Ховд аймгийн хооронд 2000 онд байгуулсан хамтран ажиллах санамж бичиг, мөн 2005 онд байгуулсан худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн чиглэлээр хамтран ажиллах тухай санамжуудын хүрээнд БНХАУ, Монгол улс, ОХУ-ын АБНУ-ыг холбосон тээврийн коридорт зориулсан “логистик терминал” буюу авто замын байгууламжыг барьж байгуулж байгаа.

АБНУ-ын Засгийн газар болон холбогдох байгуулагуудаас энэхүү замын байгууламжын ажлын явцтай танилцах, цаашид уг коридороор тээвэр худалдааг хэрхэн хөгжүүлэх боломж байгааг судлах, Монгол улсын Ховд, Баян-Олгий аймаг, БНХАУ-ын ШУОЗО-ны удирдлагууд болон холбогдох ажил хариуцсан хүмүүстэй уулзаж, санал солилцох зорилгоор толоологчдийн бүрэлдэхүүнийг илгээсэн нь онгорсон нэг дэх одор Ховд аймагт хүрэлцэн ирж уулзалт хийв.

АБНУ-ын толоологчдийн бүрэлдэхүүнд тус улсын эдийн засаг хоронго оруулалтын яамны сайдын зөвлөх Николай Николаевич Архипов, Кош-Агач мужийн захирагч Ауельхан Жазитович Джаткамбаев, тус улсын Гаалийн зохицуулалт, аналитикийн салбарын дарга Андрей Валерьевич Панов, замын болон АБНУ-д хийгдэж буй аялал жуулчлалын цогцолборт хоронго оруулагч бизнесмэнүүд багтсан байв.

Сайдын зөвлөх Н.Н.Архипов хэлэхдээ хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж байгаа гол ажил нь гурван улсыг холбосон тээврийн коридор буюу логистик терминал юм гэдгийг онцлоод энэхүү замын байгууламжыг ашиглалтанд оруулснаар гурван улсын хилийн худалдааны харилцаанд томоохон эргэлт гарна. Яагаад гэвэл одоо Шинжаанаас АБНУ-руу бүтээгдэхүүн экспортлох, тээвэр худалдаа хийхэд Монголын нутгийн хилийн гадуур тойрч асар их урт замыг туулдаг учраас худалдаа хөгжүүлэх боломж нь нэн хумигдмал.

Тэгвэл “тээврийн коридор”-ын тослийг хэрэгжүүлснээр ШУОЗО-оос Монгол улсын Ховд, Баян-Олгий аймгаар дайрч Улаанбайшинт, Ташантын боомтоор ОХУ-ын АБНУ-руу нэвтрэх боломж нээгдэж байгаа ба энэ нь тээвэр худалдааны замыг шулуутгаж, товчилохоос гадна Монгол улсын Ховд, Баян-Олгий аймагт хоёр хорштэйгээ хамтарсан хилийн худалдааг хөгжүүлэх таатай гарцыг бий болгож байгаа юм. Монгол улсын Ховд, Баян-Олгий аймгуудын хувьд хэдийгээр хvн ам цоон, зах зээлийн багтаамж тодий оргон биш ч гэсэн худалдаа эдийн засгийн хувьд одоогийн байдлаасаа илvv тvвшинд хогжиход тээврийн коридор ихээхэн тvлхэц vзvvлнэ хэмээн тайлбарлав.



Тvнчилэн замын ажил маш эрчимтэй, хурдан явагдаж байгаад сэтгэл ханамжтай буйгаа илэрхийлээд ОХУ-ын болон АБНУ-ын Засгийн газраас vнд ихээхэн анхаарал хандуулж байгааг дуулгасан.

Николей Николейвич Архипов цааш vгvvлэхдээ ОХУ-ын Засгийн газрын шийдвэрээр 2007 оноос АБНУ-д “Алтайн хондий” Аялал жуулчлалын томоохон цогцолбор тослийг хэрэгжvүлж эхэлсэн. Энэ тослийн хvрээнд одоо зочид буудлын цогцолбор, соёл, спорт, амралтын цогц байгууламжууд бий болж байна. Энэхvв цогцолборт нэг ээлжиндээ 4000 гаруй хvн vйлчлvvлж, аялал амралтанд хамрагдах боломжтой юм. Монгол улсын Улаанбаатар хотоос бизнесмenvvд хоронго оруулалт хийх, тухайлбал Монгол гэрийн цогцолбор байгуулах санал тавьсан. Бид тэр хvмvvстэй хамтарч ажиллах бодолтой байгаа.

Ташанта боомтоор орж гарч буй гадаадын аялагч жуулчдын тоо жилээс жилд нэмэгдсээр байна. Тэгэхээр энэ чиглэлээрх гурван улсын хамтын ажиллагаанд ихээхэн ирээдvй байна гэж бодож байна.

Омно нь байгуулсан санамж бичгийн хvрээнд зарим чиглэлээр тодорхой зvйлvvд хийгдсэн ч учир дутагдалтай зvйлvvд бас бий. Тиймээс гурван улсыг холбосон хогжлийн хамтын ажиллагааны хvрээнд бид цаашдын толовийг дахин нягтлаж, толовлохоор

ийнхvv “ложистик терминал”-ын дагуу явж ажиллах болсон юм.

Одоо бид соёлын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна. АБНУ-д энэ 2014 онд сонгууль болохтой холбоотойгоор соёлын хамтын ажиллагааг идэвхтэй орнvvлэх боломж жаахан хумигдмал байгаа ч, сонгуулиас хойш эрчимжvvлэх нь чухал юм.

Саяхан бас Монгол улсын Шинжлэх ухааны акедеми Горний Алтайн Улсын их сургуулийн хооронд санамж гэрээ байгуулсан. Үvний дагуу тус их сургуульд Монгол хэл соёлын ангийг шинээр нээхээр болсон. Монголоос хоёр багш ажиллуулах шийдвэр гарсан байгаагаас нэг багш саналаа ирvvлсэн. Цаашид Монголоос ажиллах багшийн тоог хоёрроор хязгаарлаж болохгvй, саналаараа очиж ажиллах багш нар байвал хvлээж авах нь зvйтэй гэсэн байр суурьтай байгаа. Энэ их сургуульд Ховд аймгаас одоо нэг оюутан суралцаж байна. Онгорсон жил дорвон оюутан байсан. Зарим нь тогсоод бас нэг оюутан хvндэтгэх шалтгаанаас сургуулиа завсарласан тал бий. Бидний хэрэгжvvлж буй гурван улсын хамтын ажиллагааны тослvvдийн хvрээнд бизнес эрхлэх сонирхолтой хvмvvс одоохондоо ховор байгаа нь энэ талаар оргон хэмжээний таниулга сурталчилгаа хийгдэхгvй байгаатай холбоотой. Иймийн тул сурталчилах ажлыг оргожvvлэх нь чухал гэж vзэж байна гэсэн юм.

Монгол тал буюу Ховд аймгийн удирдлагаас уулзалтанд оролцогчдыг аймгийн Засаг даргын орлогч М.Амарсанаа ахалсан ба Ховд аймгийн эдийн засаг, нийгмийн оноогийн байдал, гадаад хамтын ажиллагаа, цаашдын толовийн талаар товч таниулга хийсэн.

АБНУ-ын толоологчид Ховд аймгаас ходлоод Хошоотийн нvvрсний уурхай, тvvнчлэн замын байгууламж, улмаар Монгол хятадыг холбосон Булган - Такешкений хилийн боомтоор очиж, цааш Шинжаан Уйгарт зорчихоор толовлогоотэй ажээ.

□ **Г.Төрмөнх**

